

АХМАД НАСТНЫ ХАМ ШИНЖИЙГ ICOPE ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛААР

ҮНЭЛСЭН ҮР ДҮН

Н.Оюунтуяа¹, М.Отгонжаргал¹, Б.Ганжаргал¹, Н.Мөнгөнсор¹

Геронтологийн үндэсний төв¹

Цахим хаяг: oyuntuyanergui84@gmail.com

Холбогдох утас: 88055038

Судалгааны ажлын үндэслэл:

Дэлхий нийтээр ахмад настны тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна. НҮБ-ын хүн амын сангаас 2000 онд гаргасан судалгаагаар дэлхий нийтэд 60 ба түүнээс дээш настан 605 сая буюу 10 хувь байсан бол 2050 онд 22 хувь буюу 5 хүн тутмын 1 болох тооцоолол гарсан байна.¹ Монгол улсын настны өвчлөлийн тархалт, сэтгэц болон нийгмийн эрүүл мэнд судалгаагаар ахмад настны 12.6 хувь нь өдөр тутмын бүтээлч үйл ажиллагааны алдагдалтай, 29.9 хувь нь өдөр тутмын багаж хэрэгсэлтэй харьцах үйл ажиллагааны алдагдалтай, 2.2 хувь нь танин мэдэхүйн чадвар буурсан, 16.4 хувь нь сэтгэл гутралтай байна.²

ДЭМБ-аас 2019 онд “Ахмад настны цогц тусламж, үйлчилгээ (ICOPE- Integrated Care for Older People) үзүүлэх заавар удирдамжийг боловсруулсан.³ Монгол улсад ахмад настны цогц тусламж үйлчилгээний зааврыг ЭМС-ын 2024 оны 01 сарын 15 өдрийн А/22 тоот тушаалаар мөрдлөг болгож настны бие махбод, сэтгэц, нийгмийн байдлыг цогцоор нь үнэлэн, ахмад настны хам шинжийг эрт илрүүлж, түүнд суурилан эрүүл насжилтыг дэмжих, настанд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж байна.⁴

Ахмад насны доройтолд хүргэдэг үндсэн шалтгаан болох ахмад настны хам шинжийг эрт илрүүлэн, цогц тусламж үйлчилгээг үзүүлснээр эрүүл насжилтыг дэмжих чухал ач холбогдолтой байна. Иймд Геронтологийн үндэсний төвийн настан судлалын эмч, сувилагч нар ахмад настанд ICOPE үнэлгээ хийсэн үр дүнг тооцох хэрэгцээтэй байгаа нь бидний судалгаа хийх үндэслэл боллоо.

Зорилго:

Геронтологийн үндэсний төвөөр үйлчлүүлж буй ахмад настны бие махбод, сэтгэц, нийгмийн байдлыг цогцоор нь үнэлж, ахмад настны голлох 6 хам шинжийн бууралтыг ICOPE үнэлгээгэр эрт илрүүлэх, түүнд тулгуурлан урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, шинэ зааврын аргачилалыг практикт нэвтрүүлэхэд оршино.

Зорилт:

1. Геронтологийн үндэсний төвийн настан судлалын кабинетаар 2024 оны 04 сараас 10 сар хүртэлх хугацаанд үйлчлүүлсэн ахмад настныг (ICOPE) цогц үнэлгээгээр үнэлэх,
2. Ахмад настны цогц үнэлгээний (ICOPE) заавар аргачилалыг практик хэрэгцээнд турших,

	Хүнд	Бага зэрэг	Хэвийн		Бууралттай	Хэвийн		ХТ-ийн Доройтолтой	ХТ-ийн Эрсдэлтэй	Хэвийн	
55-59	1	2	11		10	4		1	2	11	
60-64	0	7	31		29	9		0	5	33	
65-69	0	9	40		33	16		1	11	37	
70-74	0	15	81		84	12		2	26	68	
75-79	2	13	64		73	6		3	29	47	
80-84	4	25	52	0.00	78	3	0.00	9	38	34	0.00
85-89	2	14	9		24	1		3	14	8	
90-94	0	4	5		8	1		0	6	3	
95-99	0	1	0		1	0		0	1	0	
Нийт	9 (2.3%)	90 (23%)	293 (74.7%)		340 (86.7%)	52 (13.3%)		19 (4.8%)	132 (33.7%)	241 (61.5%)	

Судалгаанд хамрагдсан ахмад настны танин мэдэхүйн чадвар бууралттай настан 99 (25.3%), насны хувьд 80-аас дээш насны 116 (30%) ахмад настнаас 50 (50.5%) танин мэдэхүйн бууралт ажиглагдаж, нас нэмэгдэх нь танин мэдэхүйн чадвар алдагдахад шууд хамааралтай ($p < 0.05$) байна.

Харин Хөдөлгөөний чадвар бууралт 340 (86.7%), насны хувьд ялгаагүй тохиолдож байна. Хоол тэжээлийн доройтол нь ахмад настанд 19 (4.8%) харьцангуй бага, харин эрсдэлтэй байдалд 132 (33.7%) байна.

Хүснэгт 3 . Ахмад настны хам шинжийг илрүүлэх ICOPE үнэлгээний үзүүлэлт

Гериатрийн хам шинжийн үзүүлэлт									
Нас	Харааны бэрхшээл		Р утга	Сонсгол бууралт		Р утга	Сэтгэл гутрал		Р утга
	Бэрхшээлтэй	Бэрхшээлгүй		Бууралттай	Хэвийн		Гутралтай	Хэвийн	
55-59	11	3	0.00	9	5	0.00	0	9	0.63
60-64	24	14		18	20		0	22	
65-69	35	14		32	17		0	43	
70-74	83	13		76	20		43	65	
75-79	73	6		69	10		17	68	
80-84	77	4		71	10		11	63	
85-89	25	0		23	2		6	35	
90-94	8	1		8	1		1	8	
95-99	1	0		1	0		0	1	
Нийт	337 (86%)	55 (14%)		307 (78.3%)	85 (21.7%)		78 (19.9%)	314 (80.1%)	

Судалгаанд хамрагдсан ахмад настны 337(86%) харааны бэрхшээлтэй, 307(78.3%) сонсгол бууралттай, нас нэмэгдэх нь шууд хамааралтай ($p < 0.05$) байна. Харин 78(19.9%) сэтгэл

гутралтай байсан бөгөөд нас нь сэтгэл гутралтай ($p < 0.63$) хамааралгүй болох нь харагдаж байна. Сэтгэл гутралыг бусад хам шинжтэй хамаарлыг тооцоход бие даах чадвар болон өдөр тутмын үйл ажиллагаатай ($p < 0.05$) хамааралтай судалгааны үр дүн гарсан.

Хүснэгт 3 . Ахмад настны хам шинжийг илрүүлэх ICOPE үнэлгээний үзүүлэлт

Үйлчлүүлэгчийн хүйс	Бие даах чадвар / Катз үнэлгээ /			Р утга	Өдөр тутмын бүтээлч үйл ажиллагааг тодорхойлох / Лавтоны үнэлгээ/			Р утга
	Хараат	Алдагдсан	Хэвийн		Хараат	Алдагдсан	Хэвийн	
Эрэгтэй	2	12	52	0.55	8	17	41	0.74
Эмэгтэй	7	53	266		19	77	230	
Нийт	9(2.2%)	65(16.6%)	318 (81.2%)		27(6.9%)	94(23.9%)	271 (69.2%)	

Судалгаанд эмэгтэй ахмад настан 326(83.2%) хамрагдсанаас 53(16.25%) бие даах чадвар алдагдсан, харин эрэгтэй ахмад настан 66(16.8%) хамрагдсанаас 12(18.8%) бие даах чадвар алдагдсан байгаа нь хүйсийн хувьд ойролцоо, бие даах чадвар нь хүйсийн хувьд хамааралгүй байна. Өдөр тутмын бүтээлч үйл ажиллагааг тодорхойлох Лавтоны үнэлгээгээр үнэлэхэд хүйсийн хувьд эрэгтэй настны 17(25.7%), эмэгтэй настны 77(23.6%) алдагдсан, хүйсийн хувьд хамааралгүй үр дүн гарлаа.

Хүснэгт 4 . Ахмад настны хам шинжийг илрүүлэх ICOPE үнэлгээний үзүүлэлт

Нас	Бие даах чадвар / Катз үнэлгээ /			Р утга	Өдөр тутмын бүтээлч үйл ажиллагааг тодорхойлох / Лавтоны үнэлгээ/			Р утга
	Хараат	Алдагдсан	Хэвийн		Хараат	Алдагдсан	Хэвийн	
55-59	1	0	13	0.00	1	1	12	0.00
60-64	0	1	37		0	0	38	
65-69	0	2	47		1	3	45	
70-74	1	7	88		4	11	81	
75-79	1	4	74		2	18	59	
80-84	4	30	47		11	42	28	
85-89	2	12	11		6	11	8	
90-94	0	8	1		2	7	0	
55-59	0	1	0		1	1	0	
Нийт	9(2.2%)	65(16.6%)	318 (81.2%)		27(6.9%)	94(23.9%)	271 (69.2%)	

Бие даах чадвар 80-аас дээш насанд 57 (77%) нь алдагдаж байна. Харин өдөр тутмын бүтээлч үйл ажиллагааны чадвар 81 (66.9%) алдагдсан болон хараат байгаа нь нас нь бие даах чадвар, өдөр тутмын үйл ажиллагаатай шууд хамааралтай ($p < 0.05$), 80 дээш настай ахмад настанд илүү өөртөө үйлчлэх чадвар алдагдаж байна.

Хэлцэмж:

Геронтологийн үндэсний төвөөс 2020 онд хийсэн судлаач М.Энхбаяр, Б.Эрдэнэчимэг нарын настны эрүүл мэндийн үнэлгээний үр дүнг тооцсон судалгаанд 400 ахмад настныг хамруулсан нь бидний судалгаанд хамрагдсан настны тоотой ойролцоо, харин эрэгтэй оролцогч 10%-ийн зөрүүтэй байсан. Тус судалгааны үр дүнд бие даах чадвар 85-аас дээш

настанд 40%, өдөр тутмын бүтээлч үйл ажиллагааг тодорхойлоход 30% алдагдсан болон хараат, бие даах чадвар 60% алдагдсан байсан. Бид судалгааны үр дүнгээ харьцуулахад 80-аас дээш насанд бие даах чадвар 77%, өдөр тутмын бүтээлч үйл ажиллагааны чадвар 66.9% байгаа нь 80-аас дээш настай настны дээрх чадварууд илүү алдагдаж байгаа нь ажиглагдлаа.

2011 онд судлаач Р.Оюунханд нарын Монгол Улсын настнуудын өвчний тархалт, сэтгэц болон нийгмийн эрүүл мэндийн байдал судалгааны үр дүнд настны сэтгэл гутрал нь бие даах болон бүтээл үйл ажиллагаатай үнэлгээтэй ($p < 0.01$) байгаа нь бидний судалгааны үр дүнтэй ижил байна.

Дүгнэлт:

1. Судалгаанд хамрагдсан 392 ахмад настны хам шинжийг /ICOPE/ үнэлгээгээр үнэлэхэд хөдөлгөөний чадвар бууралттай 86.7%, харааны бэрхшээлтэй 86%, сонсгол бууралттай 78.3%, сэтгэл гутралтай 20% байна. Харааны бэрхшээл нь хөдөлгөөний чадвар бууралт шууд хамааралтай ($p < 0.05$) байна.
2. ICOPE үнэлгээгээр ахмадын голлох 6 эрхтний чадварын бууралтыг эрт илрүүлсэнээр цаашид даамжрах хүндрэлээс сэргийлэх, эзэнгшлийн хугацааг уртасгахад чухал ач холбогдолтой нь харагдлаа.
3. Геронтологийн Үндэсний төвд ICOPE үнэлгээ хийх шаардлагатай ахмадын 6 хам шинжийн бууралтыг лавшруулан оношилох чих хамар хоолойн, нүд судлалын, сэтгэцийн нарийн мэргэшсэн эмч ажиллуулах нэн шаардлагатай байна.
4. ICOPE үнэлгээгээр хам шинжийн бууралттай насныг илрүүлээд түүнийг нийгэм орчинд нь яаж эмчилгээг үргэлжлүүлэх, хувийн төлөвлөгөө гаргах, нийгмийн халамж үйлчилгээний асуудлыг хариуцах эрүүл мэндийн нийгмийн ажилтан ажиллуулах шаардлагатай.

Санал:

- Ахмад настны цогц тусламж үйлчилгээний заавар /ICOPE/-ын анхны үнэлгээг бүх шатны эмнэлгийн анхан шатны нэгжид ажиллаж байгаа эмч, сувилагчдад зааж сурган, үнэлгээг бие даан хийх чадвартай болгох,
- Ахмад настны цогц тусламж үйлчилгээний заавар /ICOPE/-ын анхны үнэлгээг хийж сургах онол, дадлагыг эрүүл мэндийн боловсрол олгодог их, дээд, тусгай мэргэжлийн сургуулиудын хичээлийн хөтөлбөрт оруулах,
- Сум, өрхийн анхан шатны нэгжүүдэд ICOPE үнэлгээг хийх аргачилалыг нэвтрүүлснээр хам шинжийн бууралтыг эрт оношилох, настны хам шинжийн хүндрэлүүдээс сэргийлэх, хам шинжийн бууралт илэрсэн настнуудыг лавшруулан оношилж, шаардлагатай настнуудыг хугацаа алдалгүй дараагийн шатлалын тусламжид

илгээснээр ээнэгшлийг уртасгаж доройтолд орохоос урьдчилан сэргийлж, үндэсний эрүүл насжилтын бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Ном зүй

1. Ахмад настны тухай хууль. МУ-н хууль; 2017.01.26
2. Ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний журам. МУ-ын ЭМ-ийн сайдын тушаал; 2024.01.15-ны өдрийн А/22 тоот тушаал
3. Геронтологийн үндэсний төв. Ахмад настны цогц тусламж үйлчилгээний заавар гарын авлага. 2023
4. Р.Оюунханд нарын Монгол Улсын настуудын өвчний тархалт, сэтгэц болон нийгмийн эрүүл мэндийн байдал докторын нэг сэдэвт бүтээл Улаанбаатар; 2011.
5. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага “Номхон далай баруун бүсийн эрүүл насжилтын үйл ажиллагааны төлөвлөгөө” , Улаанбаатар хот 2021
6. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага “Эрүүл насжилтын арван жил суурь нөхцөл байдлын тайлан” Улаанбаатар хот 2022